

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар | 2020

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ, НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны 03 сарын 27 өдөр

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

Дүүргийн хэмжээнд 2020 оны 3 дугаар сарын байдлаар нийт 717 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд 618, хугацаа хэтрүүлэн 14 өргөдөл гомдол шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2019 оны 3 сард 10 хоног 07 цаг 35 минут байсан бол 2020 оны 3 сард 07 хоног 22 цаг 56 минутаар бууруулсан үзүүлэлттэй байна.

2020 оны 3 сарыг 2019 оны 3 сартай харьцуулсан байдал:

Хан-Уул дүүрэг	Нийт өргөдөл		Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Шийдвэрлэлтийн дундаж хоног		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	2019/3 сар	2020/3 сар	2019/3 сар	2020/3 сар	2019/3 сар	2020/3 сар	2019/3 сар	2020/3 сар	2019/3 сар	2020/3 сар
ИТХ	-	23	-	23	-	0	-	02х17ц 33м	-	29
ЗДТГ	138	116	131	109	1	1	07х14ц 59м	04х18ц 48м	6	24
Харъяа хэлтэс, алба, тасаг	306	451	240	377	33	6	13х11ц 10м	08х03ц 36м	94	161
Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	1	18	-	16	-	1	-	06х15ц 21м	-	26
Хороод	2	80	1	70	0	4	03х 02ц 29м	05х14ц 55м	2	38
Иргэдийн нийтийн хурал	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эмнэлэг	27	28	22	23	2	1	14х14ц 38м	09х10ц 20м	7	17
Сургууль	-	1	-	0	-	1	-	38х22ц 57м	-	0
Цэцэрлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүүргийн хэмжээнд /нийт/	474	717	394	618	36	14	11х17ц 05м	07х03ц 04м	109	295

Мөн иргэдийн хандалтыг судлан үзэхэд иргэний ахуйн зориулалтаар газар эзэмших, өмчлөх хүсэлт, газрын гурвалсан гэрээ болон, эрүүл ахуйн халдвар хамгаалал, хүнсний чанар аюулгүй байдлын хяналт, мөнгөн тусламж хүссэн хандалт их байна.

ХОЁР. ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэхэд анхаарч 7 хоног бүрийн баасан гарагт Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгуудын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн

үзүүлэлтийн тайланг бэлтгэн Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Засаг даргын Тамгын газрын шуурхай зөвлөгөөнд танилцуулан, мөн 14 хоног тутам дэргэдэх хэлтэс албадын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийн тайланг бэлтгэн Тамгын газрын дарга дүүргийн Засаг даргын шуурхайд танилцуулан шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтлөх, өргөдөл гомдлыг удирдлагын төвшинд шуурхай шилжүүлж байх талаар мэдээлэл өгч, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлж ажиллахыг анхааруулж ажиллаж байна.

Мөн дүүргийн 21 хороодыг “Өргөдөл, гомдлын дэд систем” Егр програмаар иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх, уламжлах ажлыг жигдрүүлэхэд анхаарч 14 хоног бүр хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөн дээр хороодын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийн тайланг бэлтгэн хэлтсийн даргаар уламжлуулан танилцуулах, иргэдийн эрэлт хүсэлтийг хүлээн авч “Өргөдөл гомдлын нэгдсэн систем”-д иргэний санал, гомдол, хүсэлтийг оруулах, шуурхай шийдвэрлэх, дээд байгууллагад уламжлах талаар мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтсүүдийн иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн дүүргийн Статистикийн хэлтсээс эрхлэн гаргадаг статистикийн мэдээлэл гарын авлагад нийтлүүлж байна.

ГУРАВ НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

“Нэг цэгийн үйлчилгээ”-ний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажиллалаа. Нэг цэгийн үйлчилгээний төвөөр өдөрт 200-300 иргэн тогтмол үйлчилгээ авдаг бөгөөд Төрийн үйлчилгээний мэдээлэл лавлагаа, Өргөдөл гомдол хүлээн авах төв, Эд хөрөнгийн бүртгэл, Гадаад паспорт хүлээн авах, Улаанбаатар хотын банк, Нотариат, Кадастр, Зурагчин, канон зэрэг 11 цонхоор 45 төрлийн үйлчилгээ хүргэдэг. Үүнээс гадна иргэдэд зориулан лавлагаа авдаг ТҮЦ машин, Ухаалаг мэдээллийн самбар байрлуулсан. Энэхүү самбараар дамжуулан иргэд төрийн үйлчилгээ авахад ямар бичиг баримт бүрдүүлэх хэрэгтэй байна тэр бүхний мэдээлэл бүрэн харагдана. Түүнчлэн шаардлагатай бичиг баримтаа энэхүү ухаалаг самбараасаа шууд удирдан хэвлэн авах боломжтой юм.

Нийт үйлчлүүлсэн иргэдийн тоо /давхардсан тоогоор/

Д/д	Үйлчилгээний төрөл	2020 оны 3 сар
1	УБ хотын банк	9826
2	ЭХЭБ	2041
3	Гадаад паспорт	913
4	Нотариат	
5	Канон, түргэн зурагчин	450
6	Газрын кадастр	104
	Нийт дүн	13,334